210302	Түлш, халаалт	208,208,800.00	202,917,428.63	0.00
210303	Цэвэр, бохир ус	1,733,700.00	2,085,800.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>53,455,700.00</b>	<b>51,960,605.00</b>	<b>0.00</b>
210401	Бичиг хэрэг	8,444,800.00	7,866,450.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	35,364,100.00	34,151,855.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,825,400.00	4,980,600.00	0.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	0.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	340,000.00	0.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,981,400.00	4,961,700.00	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>812,400.00</b>	<b>790,000.00</b>	<b>0.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	812,400.00	790,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>53,783,100.00</b>	<b>53,627,200.00</b>	<b>2,162,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,720,000.00	26,565,000.00	0.00
210604	Урсгал засвар	27,063,100.00	27,062,200.00	0.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,399,900.00</b>	<b>8,036,000.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,399,900.00	8,036,000.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>21,453,100.00</b>	<b>20,204,300.00</b>	<b>0.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,593,400.00	17,504,000.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	522,000.00	468,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	492,000.00	193,850.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	418,000.00	169,948.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	117,000.00	33,000.00	0.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,621,700.00	1,251,500.00	0.00
210807	Газрын төлбөр	689,000.00	584,002.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>42,711,700.00</b>	<b>41,915,680.00</b>	<b>0.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,707,000.00	35,942,560.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,004,700.00	5,973,120.00	0.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>33,427,100.00</b>	<b>33,337,340.00</b>	<b>0.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>33,427,100.00</b>	<b>33,337,340.00</b>	<b>0.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,553,000.00	12,553,000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,974,500.00	15,974,500.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,899,600.00	4,809,840.00	0.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>258,036,000.00</b>	<b>214,869,200.00</b>	<b>0.00</b>
223001	Бусад хөрөнгө	258,036,000.00	214,869,200.00	0.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>166,600,000.00</b>	<b>115,000,000.00</b>	<b>0.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	166,600,000.00	115,000,000.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,300,942,900.00</b>	<b>1,124,672,352.66</b>	<b>-65,131,472.14</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>148,969,100.00</b>	<b>136,969,100.00</b>	<b>550,487,300.00</b>
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	148,969,100.00	136,969,100.00	136,969,100.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>946,241,800.00</b>	<b>931,705,252.66</b>	<b>522,448,864.86</b>
320001	Орон нутгийн төсвөөс	946,241,800.00	931,705,252.66	659,417,964.86
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>205,732,000.00</b>	<b>55,998,000.00</b>	<b>-37,093,037.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	76,673,900.00	55,998,000.00	-9,034,900.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	129,058,100.00	0.00	-28,058,137.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	148,981,042.31	47,925,782.81
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	62,511,196.50	0.00

## 2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр / ТЗ цэвэр дүн
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,455,921.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,455,921.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,455,921.00</b>
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,029,921.00</b>
210402	Тээвэр, шатахуун	3,029,921.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>126,000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	126,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,300,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,300,000.00
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,455,921.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,455,921.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,580,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,875,921.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төрийн захиргааны байгууллагын манлайллыг дээшлүүлж, Төрийн албаны шинэчлэлийг гүнзгийрүүлж, хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хөгжлийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, удирдлагыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын үйлчилгээ мэдээллээр хангах, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

### **3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт**

#### **3.5.1 Мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 161.2 сая төгрөг болж, өмнөх оноос 249.1 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	322.2	164.4	-157.8
<b>Дүн</b>	<b>322.2</b>	<b>164.4</b>	<b>-157.8</b>

*Эх сурвалж: Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 164.4 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий орлого 101.9 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 344.5 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сан 28.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 171.0 сая төгрөг болж 24.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	1.9	2.0	0.1
Байгууллагаас авах авлага	48.3	0.00	-48.3
Хувь хүмүүст олгосон зээлийн авлага	96.8	169.0	72.2
<b>Дүн</b>	<b>147.0</b>	<b>171.0</b>	<b>24.0</b>

Эх сурвалж: Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл буурахад Эрүүл мэндийн төвийн авлага 47.1 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургуулийн авлага 0.4 сая төгрөгөөр буурсан нь голчлон нөлөөлжээ. Мөн Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага өссөн байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 129.7 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 129.7 сая төгрөг болж өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	0.1	0.00	-0.1
Бичиг хэргийн материал	0.09	0.09	0.0
Аж ахуйн материал	123.1	42.6	-80.5
Түлш шатах тослох материал	0.5	0.0	-0.5
Хүнсний материал	2.8	0.0	-2.8
Бусад хангамжийн материал	3.1	1.0	-2.1
Мал амьтад		86.0	86.0
<b>Дүн</b>	<b>129.7</b>	<b>129.7</b>	<b>0.0</b>

Эх сурвалж: Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Улсын төсвийн байгууллага болох Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Цэцэрлэгийн бараа материалыг шилжүүлж тайлагнасан, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "баяд үүлдрийн" үржлийн аж ахуй байгуулсантай холбоотойгоор 85,994.7 мянган төгрөгийн хуцыг Засаг даргын тамгын газрын мал амьтад хэсэгт бүртгэсэнтэй холбоотой байна.

### 3.5.4 Нөөцийн бараа

Нөөцийн барааны эхний үлдэгдэл 3.9 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 20.0 сая төгрөг болж 16.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Нөөцийн барааны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барааны нөөц	3.9	20.0	16.1
<b>Дүн</b>	<b>3.9</b>	<b>20.0</b>	<b>16.1</b>

Эх сурвалж: Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн барааны үлдэгдэл 16.1 сая төгрөгөөр өссөн нь барааг худалдаж авч нөөцөлсөн нь нөлөөлсөн байна.

### 3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,413.4 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 1,242.6 сая төгрөг болж 4,170.8 сая төгрөгөөр буурсан байна

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж , орон сууц	4,264.6	1,444.2	-2,820.4
Хуримтлагдсан элэгдэл	-1,030.8	-366.0	664.8
Авто тээврийн хэрэгсэл	274.1	166.6	-107.5
Хуримтлагдсан элэгдэл	-104.3	-76.6	27.7
Машин тоног төхөөрөмж (компьютер)	440.3	107.6	-332.7
Хуримтлагдсан элэгдэл	-284.8	-47.0	237.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	334.0	85.2	248.8
Хуримтлагдсан элэгдэл	-199.1	-51.6	147.5
Зам, гүүрний байгууламж	92.5	92.5	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-19.1	-37.7	18.6
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	47.4	0.0	-47.4
Номын фонд	40.1	0.07	-40.03
Бусад үндсэн хөрөнгө	94.4	61.3	-33.1
Хуримтлагдсан элэгдэл	-47.5	-23.3	24.2
Дуусаагүй барилга, байгууламж	30.0	20.9	-9,1
Программ хангамж	4.4	2.3	-2.1
Хуримтлагдсан элэгдэл	-4.0	-2.1	1.9
Бусад биет бус хөрөнгө	123.1	61.9	61.2
<b>Дүн</b>	<b>4,055.1</b>	<b>1,439.1</b>	<b>2,616.0</b>

Эх сурвалж: Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,439.1 сая төгрөг болж 2.616.0 сая төгрөгөөр буурахад гүйцэтгэлээр санхүүжих улсын төсөвт байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээс голчлон нөлөөлсөн байна. Тайлант онд худалдан авсан хөрөнгө 1.6 сая, бусад эх үүсвэрээс 266.3 сая, нийт 267.9 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, бүтцийн өөрчлөлтөөр 3,969.9 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 9.1 сая төгрөгийн хөрөнгийг дуусаагүй барилгыг ашиглалтад шилжүүлж, 20.9 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

### 3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 3.7 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэлгүй болж 3.7 сая төгрөгөөр буурсан байна

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбоотой өглөг			
Байгууллагад төлөх өглөг	0.8	0.0	-0.8
Хувь хүмүүст төлөх өглөг	2.9	0.0	-2.9
<b>Нийт дүн</b>	<b>3.7</b>		<b>3.7</b>

Эх сурвалж: Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэлгүй болж 3.7 сая төгрөгөөр буурсан нь байгууллагад төлөх болон хувь хүмүүст төлөх өглөгийг барагдуулснаас шалтгаалжээ.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,161.7 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 1,761.7 сая төгрөг болж 4,400.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,534.0	460.3	-1,073.7
Хуримтлагдсан үр дүн	1,534.1	875.6	-658.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,586.1	588.3	-997.8
<b>Дүн</b>	<b>4,654.2</b>	<b>1,924.3</b>	<b>-2,729.9</b>

Эх сурвалж: Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,924.3 сая төгрөг болж 2,729.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээ буурснаас шалтгаалжээ.

### 3.5.7 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 263.9 сая, татварын бус орлого 56.2 сая, тусламж санхүүжилтийн орлого 1,689.4 сая, нийт 2,009.4 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Малчин сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн орон нутгийн төсвийн тодотгол батлах тухай 08 дугаар тогтоолд Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 175.8 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт

төвлөрүүлэхээр батлагдсанаас, гүйцэтгэлээр 263.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 150.1 хувиар биелүүлсэн байна.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд нийт 1,375.3 сая төгрөгийн санхүүжилт авахаас аймгийн орон нутгийн төсвөөс 701.1 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 72.0 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгээр 161.3 сая, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс 28.0 сая, татварын болон татварын бус орлогоос 154.7 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 2.0 сая, Орон нутгийн хөгжлийн сан малын хөлийн татвараас 60.0 сая, Хоршоо хөгжүүлэх сан урьд оны үлдэгдлээс санхүүжих 101.0 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 69.0 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 5.3 сая, урьд оны үлдэгдлээс 3.2 сая, сумын төсвийн урьд оны үлдэгдлээс 89.6 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Малчин сумын 2022 оны төсвийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 43 дугаар тогтоолоор 1,375.3 сая төгрөгөөр баталж 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 08 дугаар тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 74.4 сая төгрөгөөр бууруулж 1,300.9 сая төгрөгөөр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,300.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 876.3 сая төгрөгийг урсгал зардалд, 258.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 166.6 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр 857.3 сая төгрөгийг урсгал зардалд, 214.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 115.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулжээ.

Гүйцэтгэлээр 667.8 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 137.0 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 263.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 56.0 сая төгрөгийг үндсэн ажиллагааны орлогоос санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,187.1 сая төгрөг буюу 91.2%-тай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 4.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4.4 сая төгрөгийг зарцуулсан байсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 3 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 9.8 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,969.3 сая төгрөгийн 0.5 хувь буюу 9.8 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 7.8 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Малчин сумын орон нутгийн орлогын төлөвлөгөө 61.0 хувиар давж биелснээс аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/697 дугаар захирамжийн дагуу сумын орон нутгийн давсан орлогоос 20.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн орлогод татаж авсан байна.

Малчин сумын 2022 оны татварын орлогын гүйцэтгэл зарим нэр төрлөөр тасарч, зарим нэр төрлөөр давж, нийт дүнгээр 108.0 сая төгрөгөөр давуулсан байна. Иймд төсвийн орлогыг бодитой төлөвлөж байхыг зөвлөмж болголоо.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 125, хугацаа хоцроож 32 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

#### **4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар**

Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 7 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 санг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 7 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар зөрчил илрээгүй.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

## 5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 88.0 мянган төгрөгийн 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. *Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

Малчин сумын 2022 оны татварын орлогын гүйцэтгэл зарим нэр төрлөөр тасарч, зарим нэр төрлөөр давж, нийт дүнгээр 88.0 сая төгрөгөөр давж, 150 хувийн биелэлттэй гарсан байна. Тухайлбал: Хөрөнгийн орлого 2.1 сая, шууд бус орлогын албан татвар 8.7 сая, бууны албан татвар 0.08 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.3 сая, Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 0.2 сая төгрөгөөр тус тус тасарч, Цалин хөлс шагнал урамшууллын орлого 21.6 сая, үйл ажиллагааны орлого 5.2 сая, хөрөнгө борлуулсны орлого 0.7 сая, үл хөдлөх эд хөрөнгийн татвар 0.5 сая, малд ногдуулах албан татвар 47.9 сая, улсын тэмдэгтийн хураамж 2.8 сая, газрын төлбөр 1.2 сая, ойн нөөц ашигласны төлбөр 6.6 сая, ан амьтан ашигласны төлбөр 12.8 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт "Сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 66.1.1 дэх заалтад "Тухайн шатны төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах" Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт "Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 59.1.7 дахь заалтад "хууль тогтоомж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 22.1-д заасан асуудлаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах", 59.1.19 дэх хэсэгт "Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах" гэж заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ сумын татварын орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Сумын татварын орлогыг бодитой төлөвлөж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс											
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн														

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Сумын татварын орлогыг бодитой төлөвлөөгүй байна.	1	88.0					1	88.0
Дүн								
Нийт дүн	1	88.0					1	88.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР /С.БАТСАЙХАН/

2023 оны 03 сарын 20-ны өдөр